

The Effect of Gender Role Conflict on Aggression: The Mediating Role of Traditional Gender Roles

Sendenkhand Nemekhbayer ^{1*} and Buyankhishig Gankhuyag ²

¹ Department of Psychology, University of the Humanities, Ulaanbaatar, Mongolia

² Department of Psychology, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Article history

Received: 25 June 2026

Accepted: 30 June 2026

*Corresponding Author:

Sendenkhand Nemekhbayer
1, Sambuu street, 8th khoroo,
Sukhbaatar district,
Ulaanbaatar 14200

Tel.:

Fax:

E-mail:

sendenkhand.n@humanities.mn

DOI: 10.5281/zenodo.21059824

Abstract: Adolescence is a critical stage in which gender expectations become deeply internalized and influence behavioral and emotional expression. Traditional social norms may conflict with one's sense of self-expression, potentially increasing the risk of aggressive behavior. Boys are more likely to exhibit physical aggression, while girls tend to suppress anger. These differences arise not only from biological factors but also from social-psychological expectations and gender role conflict. This study aimed to examine how gender role conflict affects adolescents' aggressive behavior and whether traditional masculinity and femininity mediate this relationship. A total of 398 adolescents aged 12–18 years (199 boys and 199 girls) participated in the study. The Gender Role Conflict Scale, the Traditional Masculinity–Femininity Scale, and the Buss–Perry Aggression Questionnaire were used for data collection. Results indicated that male students scored higher in both physical aggression and gender role conflict. Physical aggression increased with higher masculinity and decreased with higher femininity. Gender role conflict did not directly influence aggression but showed an indirect effect through masculinity traits. Overall, the findings reveal that the inconsistency between traditional gender expectations and self-expression influences adolescent aggression through traditional gender roles. Reducing rigid gender expectations and fostering more flexible gender attitudes may support healthier emotional expression and help prevent aggressive behaviors among adolescents.

Keywords: gender role conflict, traditional masculinity, traditional femininity, aggression, mediating variable

Оршил

Өсвөр нас бол хувь хүний жэндэрийн баримжаа, жэндэрийн үүрэг хүлээлтийг ухамсарлаж эхэлдэг чухал үе юм. Энэ үед хүүхдүүд нийгмийн хэвшмэл ойлголтыг өөртөө шингээж, түүний дагуу авирлах хандлагатай болдог (Bem, 1981). Тухайлбал, эрэгтэй хүүхдүүдээс хүчтэй, зоримог, хатуу чанартай байхыг шаарддаг бол эмэгтэй хүүхдүүдээс дуулгавартай, уян зөөлөн байдлыг чухалчилдаг (Eagly & Wood, 2012). Ийм хүлээлт нь хүүхдүүдийн сэтгэл хөдлөлийн илрэл,

зан үйл, тэр дундаа түрэмгий зан чанарт хэрхэн нөлөөлж байдаг. Өмнөх судалгаануудын үр дүнд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү түрэмгий авир гаргах нь түгээмэл байдаг гэж дүгнэсэн (Archer, 2004). Гэхдээ энэ ялгаа нь зөвхөн биологийн бус, нийгэм-сэтгэлзүйн хүчин зүйлсээс ихээхэн хамаардаг болохыг судлаачид онцолдог (Hyde, 1984). Өөрөөр хэлбэл, жэндэрийн үүргийн хэвшмэл ойлголт нь хүмүүсийн түрэмгий авир гаргах байдалд тодорхой хүрээнд нөлөөлдөг байна. Жишээлбэл, эмэгтэй хүүхдүүд уур, бухимдлаа шууд илэрхийлэх нь эмэгтэй хүний дүр төрхтэй

зөрчилддөг хэмээн ойлгож, сэтгэл хөдлөлөө дарах буюу өөрөөр илэрхийлэх хандлагатай байдаг (Zillmann, 1978).

Зиллманы “Сэрэл шилжих онол” (excitation transfer theory)-оор бол сэтгэл хөдлөлийн өндөр сэрэл үүсэх үед тухайн сэрлийг тодорхой эх сурвалжтай холбож тайлбарлах хандлага байдаг. Энэ нөхцөлд жендерийн үүрэг нь тухайн хүүхдийн сэрэлд хариу үзүүлэх хэлбэрийг зохицуулж болзошгүй. Иймд өсвөр насны охид өдөөн хатгалгад өртсөн ч түрэмгий зан гаргахгүй байх магадлалтай байдаг. Харин уламжлалт жендерийн хэвшмэл ойлголтод нийцдэггүй, өөрөөр хэлбэл, жендерийн үүргийн зөрчил илэрсэн тохиолдолд энэ хандлага өөрчлөгдөж болох юм. Түүнчлэн жендерийн үүргийн зөрчил буюу тухайн хүний хүйсийн хүлээлтэд нийцээгүй зан авир нь сэтгэлзүйн стресс, дотоод зөрчлийг бий болгож, улмаар түрэмгий авир гаргах эрсдэлтэй холбогдож болохыг судлаачид анхааруулдаг (O’Neil, 2008). Иймээс энэ судалгаагаар өсвөр насны хүүхдүүдийн жендерийн үүргийн зөрчил нь түрэмгий зан авирт хэрхэн нөлөөлж байгааг, мөн уламжлалт жендерийн үүргийн хүлээлт энэ хамаарлыг хэрхэн зуучилж байгааг судлахаар зорьсон болно.

Жендерийн үүрэг нь нийгэм, соёлын хүрээнд эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдээс хүлээдэг хандлага, үйлдэл, зан үйлийг хэлнэ. Эдгээр үүргүүд нь түүх, соёл, шашин, эдийн засаг зэргээс хамааран хэлбэлздэг ч олон нийгэмд уламжлалт жендерийн хүлээлт нь сэтгэлзүйн болон нийгмийн дарамт үүсгэдэг хэвээр байна. Жендерийн үүргийн зөрчил нь хувь хүн эдгээр хүлээлтэд нийцэх гэж оролдох үед сэтгэлзүйн эсвэл зан үйлийн түвшинд гарч ирдэг дотоод зөрчлийг илэрхийлдэг.

Уламжлалт жендерийн үүрэг нь эрэгтэйчүүдийг ноёрхогч, хүчирхэг удирдагч байхаар, эмэгтэйчүүдийг халамжлагч, дуулгавартай, сэтгэл хөдлөлөө илэрхийлэгч байхаар тодорхойлдог. Ийгли (Eagly, 1987) энэ үзэгдлийг нийгмийн үүргийн онолоор тайлбарласан бөгөөд нийгэм эдгээр үүргийг дахин бий болгож, улам бэхжүүлдэг гэж үзсэн. Боловсрол, хэвлэл мэдээлэл, гэр бүлийн хүрээлэл нь хүүхдийг жендерийн үүргийн талаарх үзэл санаагаар төлөвшүүлдэг нь өсвөр наснаас хойш тодорхой дүр төрх, үйлдлийн хүлээлтийг бий болгодог.

Бэмийн “Жендерийн схемийн онол” нь хувь хүмүүсийн сэтгэлзүйн дотоод бүтцэд төвлөрдөг (Bem, 1981). Энэхүү онолд хүмүүс өөрийн зан үйлийг тайлбарлах, хянах зорилгоор нийгмээс

өгөгдсөн жендерийн үүргийн схемд тулгуурладаг гэж үздэг. Ийм схем нь жендерийн хэвшмэл ойлголтыг дахин баталгаажуулж, хувь хүний өсөлт, өөрийгөө илэрхийлэх боломжийг хязгаарладаг. Уиллиамс ба Бэс нар жендерийн хэвшмэл ойлголтыг судалсан бөгөөд эмэгтэйчүүдийг энэрэнгүй, дуулгавартай, гадаад төрхөөрөө үнэлдэг бол эрэгтэйчүүдийг шийдэмгий, логиктой, ноёрхогч гэж үнэлдэг тогтоосон (Williams & Best, 1980). Эдгээр хэвшмэл ойлголт нь хүмүүсийн өөрийгөө үнэлэх үнэлэмж, сонголт, бусдад хандах хандлагыг удирдаж, жендерийн үүргийн зөрчилд хүргэдэг. Уламжлалт жендерийн үүргийн хүлээлт нь хувь хүний дотоод хүсэл, үнэт зүйл, нөхцөл байдалд нийцэхгүй байх үед зөрчил үүсдэг. Жишээлбэл:

- Эрэгтэйчүүд сэтгэл хөдлөлөө илэрхийлэхэд “сул дорой” гэж үзэгдэхээс эмээж, сэтгэл хөдлөлөө дардаг.
- Эмэгтэйчүүд удирдах байр суурьд хүрэхэд “түрэмгий” эсвэл “эмэгтэй хүнд зохимжгүй” гэж үнэлэгддэг.

Эдгээр нь жендерийн үүргийн зөрчлийн үндэс болж, сэтгэлзүйн стресс, доогуур өөрийгөө үнэлэх байдал, сэтгэл гутрал үүсгэдэг. Гриммел ба Стерн нарын судалгаагаар, хувь хүний бодит зан төлөв нь нийгмийн хүлээлттэй нийцэхгүй байх үед өөрийгөө үнэлэх байдал буурч, сэтгэл гутрал үүсэх эрсдэл нэмэгддэг болохыг тогтоожээ (Grimmell & Stern, 1998).

Энэ нь жендерийн үүргийн зөрчилтэй холбоотойгоор сэтгэлзүйн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг байна. Мөн Гүүд ба Минтз нарын судалгаагаар, эрэгтэйчүүдийн жендерийн үүргийн зөрчил нь сэтгэл гутралын түвшинтэй эерэг хамааралтай байгааг харуулсан (Good & Mintz, 1990). Ө нейл жендерийн үүргийн зөрчлийг “Хувь хүн уламжлалт жендерийн үүргийг баримтлах гэж оролдох үед гарч ирэх сэтгэлзүйн зөрчил, дарамт, бэрхшээл” хэмээн тодорхойлсон (O’Neil, 1981). Энэ онол нь жендерийн үүргийн хэт хязгаарлалтаас үүдэлтэй сөрөг үр дагаврыг тайлбарладаг. Жендерийн үүргийн зөрчил нь хувь хүний сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, харилцаанд оролцох, өөрийгөө үнэлэх, зорилгод хүрэх үйл явцад саад болдог. Жендерийн үүргийн зөрчлийг дараах дөрвөн үндсэн хэмжүүрээр хэмждэг:

1. Сэтгэл хөдлөлөө илэрхийлэхтэй холбоотой зөрчил: Эрэгтэй хүнийг “хүчтэй” байлгах нийгмийн дарамтаас болж сэтгэл хөдлөлөө нуух,

илэрхийлэхээс айх байдал.

2. Эрх мэдэл, амжилт, өрсөлдөөнд хэт автах: Эрэгтэй хүнийг байнга амжилт гаргах ёстой гэх хүлээлтэд нийцүүлэх гэж хичээх нь стресс үүсгэдэг.
3. Ажил ба гэр бүлийн үүргийн зөрчил: Гэр бүлээ тэжээх үүрэгтэй байхыг шаардахын зэрэгцээ ажил дээрээ өндөр амжилт гаргах хэрэгтэй гэсэн дарамт.
4. Хүйс хоорондын харилцаан дахь зөрчил: Өөрийн жендэрийн үүргийн дагуу бусдад хандах хандлага, ялангуяа эмэгтэйчүүдтэй харилцахад илрэх үл ойлголцол, түгшүүр.

Судалгаануудад жендэрийн үүргийн зөрчил нь сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, харилцааны хүндрэл, донтох зан үйлийн суурь нөхцөл болдог болохыг тогтоосон байдаг (Good & Mintz, 1990; Grimmell & Stern, 1998; O'Neil, 2008). Малонда Видал нар уламжлалт эрэгтэйлэг үүргийг баримтлах өсвөр насныхны дунд сэтгэл хөдлөлөө илэрхийлэхгүй байх нь бухимдлыг дотооддоо хуримтлуулж, улмаар түрэмгий зан авир гаргах магадлалыг нэмэгдүүлдгийг судалгаагаар харуулсан (Malonda-Vidal et al., 2021). Түүнчлэн Мерино нар уламжлалт эрэгтэйлэг хүлээлтэд нийцэхгүй байх үед өсвөр насны эрэгтэйчүүд илүү их уур хилэн, түгшүүр мэдэрч, эрүүл мэндэд сөрөг зан үйл (жишээлбэл, архидалт, хүчирхийлэл) илрүүлэх хандлагатай байдгийг тогтоосон (Merino et al., 2021). Энэ нь жендэрийн үүргийн зөрчил нь зөвхөн сэтгэлзүйн бус, зан үйлийн түвшинд ч илэрдэг болохыг харуулж байна.

Фидаззо, Барон ба Стивс нар охидын дунд хийсэн судалгаагаар уламжлалт эмэгтэйлэг хүлээлтүүд нь сэтгэл хөдлөлийн шууд илрэлээс зайлсхийж, харин шууд бус түрэмгий авир (жишээлбэл, хов жив тараах, нийгмийн орчноос гадуурхах) илрэх нөхцөл болдог гэж үзсэн (Fidazzo et al., 2022). Энэ нь жендэрийн хүлээлт нь түрэмгий байдлын хэлбэрийг ялгаатай илрүүлэх боломжтойг нотолж байна.


Махалик нар “Conformity to Masculine Norms Inventory” (CMNI) гэх хэмжүүрээр судалгаа явуулахдаа сэтгэл хөдлөлөө илэрхийлэхээс зайлсхийх, хүч чадалд тэмүүлэх, өрсөлдөөнд давамгайлах хандлагууд нь түрэмгий зан авирын таамаглах хүчин зүйл болохыг дэмжсэн (Addis & Mahalik, 2003; Mahalik et al., 2003). Түүнчлэн, уламжлалт жендэрийн үүрэгт хэт нийцэхийг

эрмэлзэх нь хувь хүний сэтгэлзүйн эрх чөлөөг хязгаарлаж, нийгмийн харилцаанд сөргөөр нөлөөлдөг болохыг дүгнэсэн. Эдгээр судалгаануудын дүнгээс харахад жендэрийн үүргийн зөрчил нь түрэмгий зан авирт хүчтэй нөлөө үзүүлж болох бөгөөд энэ хамаарлыг уламжлалт жендэрийн хүлээлтийн хүч хэр зэрэг давамгайлж байгаагаас шалтгаалан зуучлах замаар зохицуулж болзошгүй юм. Иймээс жендэрийн үүргийн зөрчлийг зөв таних, ойлгох, боловсролын болон сэтгэл зүйн арга зүйгээр зохистой хандлага төлөвшүүлэх нь өсвөр насныхны сэтгэлзүйд эерэгээр нөлөөлөх чухал алхам юм.

Дараах таамаглалыг дэвшүүлэв. Үүнд:

- H1: Жендэрийн үүргийн зөрчил нь түрэмгийллийг нэмэгдүүлдэг.
- H2: Уламжлалт жендэрийн үүрэг нь жендэрийн зөрчилтэй хамааралтай.
- H3: Уламжлалт жендэрийн үүрэг нь түрэмгийллийг нэмэгдүүлдэг.
- H4: Жендэрийн үүргийн зөрчил нь уламжлалт жендэрийн үүргийг зуучлах нөлөөгөөр дамжин түрэмгийллийг нэмэгдүүлдэг.

Зураг 1. Судалгааны таамаглал



Судалгааны арга зүй

Жендэрийн үүргийн зөрчил (Gender role conflict scale). Энэхүү асуулга нь жендэрийн үүргийн талаарх хувь хүний ойлголтыг илэрхийлдэг 10 зүйлээс бүрдсэн хэмжүүр юм (Brown & Gladstone, 2012). Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүлээх ёс зүй, шийдвэр гаргах эрх мэдэл, гэр бүлийн жендэрийн үүрэг зэрэг асуудлуудыг багтаасан ба 10 асуултын нийлбэр оноог нь бодож нэгдсэн оноог гаргана. Бага оноотой байх тусам уламжлалт жендэрийн итгэл үнэмшилтэй байгааг илэрхийлэх бол өндөр оноотой байх тусам феминист жендэрийн үүргийн итгэл үнэмшилтэйг илтгэнэ. Асуулгын найдварт чанарыг шинжлэхэд найдварт чанар хангахуйц байсан болно (Cronbach's

$\alpha=.703$).


Уламжлалт жендэрийн үүргийн хэмжүүр (Traditional masculinity femininity role). Уламжлалт эрэгтэй, эмэгтэй байдлын хэмжүүр нь хувь хүний өөрийн гэсэн хүйсийн дүр төрхийг илэрхийлдэг 6 асуулттай бүхий хэмжүүр юм. Эдгээр асуултууд нь жендэрийн үүрэг, жендэрийн үүргийг илүүд үзэх, жендэрийн үүрэг баримжаа гэсэн гурван төвлөрсөн талыг хамардаг. Асуултад хариулахдаа 1-ээс (огт эрэгтэйлэг биш) 7 хүртэл (бүрэн эрэгтэй) ба 1-ээс (огт эмэгтэйлэг биш) 7 хүртэл (бүтэн эмэгтэйлэг) тоогоор хариулах ба 6 асуултын дундажаар эрэгтэйлэг, эмэгтэйлэг байдлын индексийг тооцно (Kachel et al., 2016). Асуулгын найдварт чанарыг шинжлэхэд найдварт чанар өндөр байсан (Cronbach's $\alpha=.961-977$).

Бусс Перригийн түрэмгийллийн асуулга (Buss Perry Aggression Questionnaire). Энэхүү асуулга нь 29 асуулттай ба хувь хүний түрэмгийллийн түвшинг үнэлэхэд өргөн хэрэглэгддэг, өөрийн үнэлэмжийг асуулга юм. 1990-ээд онд Арнольд Х.Бусс, Марк Перри нар боловсруулсан. Энэхүү асуулга нь түрэмгийллийг бие махбодийн түрэмгийлэл, үгэн түрэмгийлэл, уур хилэн, дайсагнал гэсэн дөрвөн үндсэн хэмжигдэхүүнд хуваадаг. Асуулгын найдварт чанарыг шинжлэхэд найдварт чанар хангахуйц байсан болно (Cronbach's $\alpha=.884$, McDonald's $\omega=.891$).

Түүвэр


Энэхүү судалгаанд нийт 497 оролцсон ба судалгааны өгөгдлийг цэвэрлэн 473 оролцогчдын дата дээр боловсруулалт хийв.

Зураг 2. Судалгаанд оролцогчдын эцэг эхтэйгээ хамт амьдардаг болон хүйсийн харьцаа




Судалгаанд хамрагдсан эмэгтэй оролцогчид 70.2 хувийг ($n = 332$) эзэлж байсан бол эрэгтэй оролцогчид 29.8 хувь ($n = 141$)-ийг бүрдүүлж байв. Хүйсийн энэхүү хазайлт нь судалгаанд эмэгтэй сурагчид идэвхтэй оролцсон болохыг харуулж байна. Түүнчлэн оролцогчдын дийлэнх буюу 93.0 хувь ($n = 440$) нь эцэг, эхийн хамт амьдардаг гэж хариулсан байна. Харин 7.0 хувь ($n = 33$) нь эцэг, эхийн аль нэгтэй, эсвэл огт хамт амьдардаггүй гэж хариулжээ.

Зураг 3. Судалгаанд оролцогчдын насны харьцаа



Оролцогчдын насны тархалт 12-оос 18 насны хооронд байсан ($M = 15.5$, $SD = 1.37$). Нийт оролцогчдын 1.5 хувийг ($n = 6$) 12 настай сурагчид эзэлж байв. Мөн 13 настай сурагчид 12.6 хувийг ($n = 50$) эзэлсэн. 14 настай оролцогчид 16.6 хувь ($n = 66$), 15 настай нь 18.6 хувь ($n = 74$), 16 настай нь 24.1 хувь ($n = 96$), 17 настай нь 22.1 хувь ($n = 88$)-ийг тус тус эзэлжээ. Эдгээр дөрвөн насны бүлэг нийлээд нийт оролцогчдын 81.2 хувийг бүрдүүлж байсан нь өсвөр үеийн сэтгэл зүйн хөгжлийн чухал үе шат болох 14–17 насныхан судалгаанд давамгайлж оролцсоныг харуулж байна. Харин 18 настай сурагчид 4.5 хувийг ($n = 18$) эзэлсэн бөгөөд энэ нь уг насны бүлэг судалгаанд харьцангуй бага төлөөлөлж байна.

Зураг 4. Судалгаанд оролцогчдын ангийн харьцаа



Судалгаанд оролцогчдын ангийн түвшний тархалтыг авч үзвэл, хамгийн бага төлөөлөлтэй бүлэг нь 6-р ангийн сурагчид байсан бөгөөд тэд нийт оролцогчдын 0.5 хувийг ($n = 2$) эзэлж байв. 7-р ангийн сурагчид 14.6 хувийг ($n = 58$) эзэлсэн байна. 8-р ангийн сурагчид нийт оролцогчдын 17 хувийг ($n = 68$) бүрдүүлсэн бөгөөд оролцооны түвшнээрээ эхний гурван байрт

багтаж байв. Түүнчлэн, 9-р ангийн сурагчид 19.6 хувь ($n = 78$), 10-р ангийн сурагчид 22.6 хувь ($n = 90$)-тайгаар оролцсон байна. 11-р ангийн сурагчид мөн өндөр хувь эзэлж, нийт оролцогчдын 20.6 хувийг ($n = 82$) бүрдүүлжээ. Харин 12-р ангийн сурагчдын эзлэх хувь харьцангуй бага буюу 5 хувь ($n = 20$) байна.

Үр дүн ба хэлэлцүүлэг

Хүснэгт 1. Хувьсагчдын дундаж, их, бага утга, стандарт хазайлт

	Mean	SD	Min	Max
Эрэгтэйлэг байдал	3.49	2.15	1.00	7.00
Эмэгтэйлэг байдал	4.11	2.22	1.00	7.00
Бие махбодийн түрэмгийлэл	22.8	6.60	9.00	43.0
Үгэн түрэмгийлэл	12.3	3.82	5	25
Уур хилэн	19.9	5.38	7.00	35.0
Дайсагнал	25.4	7.48	8.00	40.0
Жендэрийн үүргийг зөрчил	25.5	6.26	9.00	45.0

Жендэрийн баримжааны түвшнийг тодорхойлох “эрэгтэйлэг” болон “эмэгтэйлэг” байдлын хэмжүүрүүдийн хувьд оролцогчдын эмэгтэйлэг байдал ($M = 4.11$, $SD = 2.22$) нь эрэгтэйлэг байдлаас ($M = 3.49$, $SD = 2.15$) өндөр оноо авчээ. Түрэмгий байдлын хувьд бие махбодийн түрэмгийлэл ($M = 22.8$, $SD = 6.60$), үгэн түрэмгийлэл ($M = 12.3$, $SD = 3.82$), уур хилэн ($M = 19.9$, $SD = 5.38$), дайсагнал ($M = 25.4$, $SD = 7.48$) зэрэг үзүүлэлтүүдийг хэмжсэн бөгөөд эдгээр нь сөрөг сэтгэл хөдлөл болон түрэмгий зан үйлийн түвшин, хэлбэрийг төлөөлнө. Түрэмгийллийн оноонуудын дундаж нь дунд зэргийн түвшинд байгаа ч хамгийн их утгууд (43, 35, 40 гэх мэт) нэлээд өндөр байгаагаас үзэхэд зарим оролцогчдын хувьд илүү тод илрэлтэй байж болохыг харуулж байна. Үүнээс харахад хувь хүний сөрөг сэтгэл хөдлөлийн хариу урвал, хандлага нь харилцан адилгүй бөгөөд статистикийн хувьд өөр хоорондоо ялгаатай бүлэг байгааг илтгэж болзошгүй юм. Жендэрийн үүргийн зөрчлийн хэмжүүрийн дундаж нь 25.5 ($SD = 6.26$), хамгийн бага нь 9, хамгийн их нь 45 оноо байна.

Хүснэгт 2. Хүйсээс хамаарсан ялгаа

	t	p
Эрэгтэйлэг байдал	-34.189 ^a	<.001
Эмэгтэйлэг байдал	32.505 ^a	<.001
Бие махбодийн түрэмгийлэл	-2.843	0.005
Үгэн түрэмгийлэл	0.487	0.626
Уур хилэн	0.865	0.388
Дайсагнал	1.732 ^a	0.084
Жендэрийн үүргийн зөрчил	-7.890	<.001

Судалгаанд оролцсон эмэгтэй ($n = 332$) ба эрэгтэй ($n = 141$) сурагчдын жендэрийн үүрэг, түрэмгийлэл, жендэрийн үүргийн зөрчлийн үзүүлэлтүүд ялгаатай эсэхийг шинжлэхэд дараах статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсан болно. Үүнд:

- Эрэгтэй сурагчдын эрэгтэйлэг шинж ($M=6.25$, $SD=1.05$) эмэгтэй сурагчдаас ($M=2.30$, $SD=1.19$) илүү буюу энэ ялгаа статистикийн хувьд маш өндөр ач холбогдолтой байв ($t(471) = -34.189$, $p < .001$).
- Эмэгтэй сурагчдын эмэгтэйлэг шинж ($M = 5.33$, $SD = 1.39$) нь эрэгтэй сурагчдынхаас ($M = 1.29$, $SD = 0.75$) мөн статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байсан ($t(471) = 32.505$, $p < .001$). Энэ нь уламжлалт эмэгтэйлэг шинж чанар эмэгтэй сурагчдад илүү давамгай байдлаар илэрч байгааг харуулж байна.
- Эрэгтэй сурагчдын бие махбодийн түрэмгийлэл ($M = 23.98$, $SD = 6.68$) нь эмэгтэй сурагчдаас ($M = 22.11$, $SD = 6.46$) илүү өндөр байсан ($t(471)=2.843$, $p=.005$). Энэхүү үр дүн нь өмнөх судалгаануудтай нийцэж, эрэгтэй хүүхдүүд хүч хэрэглэсэн зан үйлээр илүү хариу үйлдэл үзүүлэх хандлагатай байдгийг баталж байна.
- Эрэгтэй сурагчид ($M=28.84$, $SD= 6.03$) эмэгтэй сурагчдаас ($M=24.20$, $SD= 5.77$) илүү өндөр түвшний жендэрийн үүргийн зөрчил мэдэрч байгааг илтгэж байна($t(471) = -7.890$, $p < .001$) байв. Энэ нь эрэгтэй хүүхдүүд нийгмийн уламжлалт эрэгтэйлэг хүлээлттэй нийцэхийн тулд дотоод дарамт, сэтгэлзүйн зөрчилд илүү өртдөг болохыг харуулж байж болзошгүй юм.

Харин үгэн түрэмгийлэл, уур хилэн, дайсагнал гэсэн хувьсагчдын хувьд хүйсийн ялгаа илрээгүй ($p>.05$). Түүнчлэн эцэг эхтэйгээ амьдардаг эсэх болон хэддүгээр ангид суралцдаг эсэхээс шалтгаалаад судалгаанд оролцогчдын жендэрийн үүрэг ба зөрчил, түрэмгий зан үйлд ялгаа илэрсэнгүй ($p>.05$).

Хүснэгт 3. Наснаас хамаарсан ялгаа


	F	p
Эрэгтэйлэг байдал	2.992	0.015
Эмэгтэйлэг байдал	1.592	0.171
Бие махбодийн түрэмгийлэл	1.760	0.128
Үгэн түрэмгийлэл	0.961	0.462
Уур хилэн	0.339	0.913
Дайсагнал	2.217	0.058
Жендэрийн үүргийн зөрчил	0.696	0.654

Судалгаанд оролцогчдын насны бүлгүүдэд жендэрийн үүрэг ба зөрчил, түрэмгийлэл ялгаатайгаар илэрч буй эсэхийг олон хүчин зүйлийн шинжилгээгээр (One Way ANOVA) шинжлэв. Үр дүнд, эрэгтэйлэг байдлын хувьд наснаас хамаарсан статистикийн ач холбогдол бүхий ялгаа илэрсэн ($F(6, 46.8) = 2.992$, $p = 0.015$). Энэ нь өсвөр насны сурагчдын дунд эрэгтэйлэг зан чанарын илрэл нь нас ахихын хэрээр өөрчлөгдөж байгааг илтгэж байна. Пост Хок шинжилгээний үр дүнгээс үзэхэд, 15 настай

сурагчид (дунджаар 2.96 оноо) болон 18 настай сурагчид (дунджаар 4.78 оноо)-ын хоорондын ялгаа статистикийн хувьд утгатай байв ($p = 0.009$). Мөн 14 настай сурагчдын (дунджаар 3.21 оноо) эрэгтэйлэг байдал болон 18 настнуудын дундаж хоорондын зөрүү мөн ач холбогдолтой ($p = 0.046$) байна. Энэ нь ахлах ангийн сурагчид, ялангуяа 18 настнууд нь бага ангийн сурагчидтай харьцуулахад өөрийгөө хүчирхэг, шийдэмгий, удирдан чиглүүлэх чадвартай хэмээн илүү үнэлдэг ба эрэгтэйлэг байдал илүү давамгайлал элэрч буйг харуулж байна. Ийм өөрчлөлт нь өсвөр насны сүүл үед бие даах, өөрийн байр суурийг илэрхийлэх хэрэгцээ нэмэгдэх, мөн нийгмийн болон соёлын хүлээлт эрчимжихтэй холбоотой байж болох юм.

Харин эмэгтэйлэг байдал, бие махбодийн түрэмгийлэл, үгэн түрэмгийлэл, уур хилэн, дайсгал, жендерийн үүргийн зөрчил зэрэг бусад хувьсагчид дээр насны бүлгүүдийн хооронд ялгаа илрээгүй байна ($p > .05$). Энэ нь тухайн үзүүлэлтүүд нас ахихын хэрээр тогтворжсон хандлагатай байж болохыг, эсвэл насны ялгаа нь тэдгээр хувьсагчид дээр онцгой нөлөө үзүүлээгүй болохыг илэрхийлж болно.

Зураг 4. Хувьсагчдын хамаарал



Судалгааны хувьсагч хооронд хамаарал илэрч буй эсэхийг Пирсоны шинжилгээгээр (Pearson correlation) шинжлэв. Үр дүнд, эрэгтэйлэг байдал нь бие махбодийн түрэмгийлэлтэй эерэг хамааралтай байна ($r = 0.225$, $p < .001$). Энэ нь эрэгтэйлэг зан чанартай гэж өөрийгөө тодорхойлдог сурагчид илүү их бие махбодийн хүч хэрэглэсэн авир гаргах магадлалтай байгааг илтгэж байна. Харин эмэгтэйлэг байдал болон бие махбодийн түрэмгийлэл хооронд сөрөг хамаарал ажиглагдсан ($r = -0.165$, $p < .001$), өөрөөр хэлбэл, илүү эмэгтэйлэг шинжтэй сурагчид бие махбодийн түрэмгий авир гаргах нь харьцангуй бага байжээ. Түүнчлэн эрэгтэйлэг байдал нь жендерийн үүргийн зөрчилтэй эерэг хамааралтай байна ($r = 0.316$, $p < .001$). Энэ нь уламжлалт жендерийн үүргийн хүлээлтэд нийцэхээр эрэгтэйлэг зан чанарыг илүүтэй илэрхийлдэг өсвөр насны хүүхдүүд тухайн хүлээлттэй зөрчилдөх, сэтгэлзүйн дарамт мэдрэх

байдал нэмэгдэх магадлалтай болохыг илтгэнэ. Харин эмэгтэйлэг байдал нь жендерийн үүргийн зөрчилтэй сөрөг хамааралтай байна ($r = -0.323$, $p < .001$), энэ нь эмэгтэйлэг шинжийг илүүтэй илэрхийлдэг сурагчид уламжлалт жендерийн хүлээлттэй зөрчилдөх нь бага байна.

Судалгаанд хамрагдсан өсвөр насны сурагчдын бие махбодийн түрэмгий авир нь тэдний эрэгтэйлэг зан чанарын түвшинтэй статистикийн хувьд ач холбогдолтой эерэг хамааралтай болох нь регрессийн шинжилгээний үр дүнгээр гарч ирлээ. Шинжилгээнд стандартчилсан хувьсагч ашигласан ба регрессийн тэгшитгэл дараах байдлаар илэрч байна.


$$\text{Physical Aggression} = 0.373 \times \text{Masculinity} + 0.176 \times \text{Femininity} + \epsilon$$

- Эрэгтэйлэг шинж чанар нь бие махбодийн түрэмгийлэлд ач холбогдолтой, эерэг нөлөөтэй байв ($\beta = 0.373$, $p < .001$). Энэ нь нэг нэгжээр илүү эрэгтэйлэг шинжтэй сурагчдын бие махбодийн түрэмгий авирын оноо дунджаар 0.373 нэгжээр өсөх магадлалтайг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, эрэгтэйлэг чиг хандлага өндөр байх нь илүү хүч хэрэглэсэн зан авиртай холбоотой байна.
- Эмэгтэйлэг шинж чанар (ZFeminine) нь бие махбодийн түрэмгийлэлд эерэг нөлөөтэй боловч статистикийн хувьд ач холбогдолгүй байв ($\beta = 0.176$, $p = 0.077$). Иймд эмэгтэйлэг зан чанар түрэмгий авирт нөлөөлж болох ч энэхүү судалгаанд баттай дүгнэлт хийх хангалттай үндэслэлгүй байна.

Эрэгтэйлэг болон эмэгтэйлэг байдал нь бие махбодийн түрэмгийллийн 5.4 хувийг тайлбарлаж байна ($R^2 = 0.054$). жижиг хэсгийг тайлбарлаж чадаж байгааг харуулж байна.

Өөрөөр хэлбэл, уламжлалт эрэгтэйлэг байдал өндөр байх тусам өсвөр насны хүүхдүүд илүү бие махбодийн хүч хэрэглэсэн зан авир гаргах магадлалтай байна. Энэ нь уламжлалт нийгмийн хүлээлт буюу “эрэгтэй хүн хүчтэй, шийдэмгий байх ёстой” гэх ойлголт хүүхдүүдийн зан авирт хэрхэн нөлөөлж байгааг илтгэж байсан бол эмэгтэйлэг байдал болон түрэмгий авирын хоорондын хамаарал сул байна.

Зураг 5. Зуучлагч хувьсагчийн шинжилгээ



Жендэрийн үүргийг зөрчил нь уламжлалт жендэрийн үүргийн зуучлах нөлөөгөөр дамжин бие махбодийн түрэмгийлэлд нөлөөлж буй эсэхийг зуучлах хувьсагчийн шинжилгээгээр шинжлэв. Судалгааны үр дүнгээс харахад, жендэрийн үүргийн зөрчил нь бие махбодийн түрэмгийлэлд шууд нөлөөлөхгүй байсан ч гэлээ уламжлалт жендэрийн үүргээр дамжин шууд бусаар нөлөөлж байна. Тодруулбал, жендэрийн зөрчил нь өсвөр насны сурагчдын эрэгтэйлэг (indirect effect=0.0724, $p<.001$) болон эмэгтэйлэг (indirect effect=0.0497, $p=0.007$) зан чанарт нөлөөлж, цаашлаад түрэмгий зан авирт дам нөлөө үзүүлж байсан болно. Тухайлбал,

- Жендэрийн үүргийн зөрчил нь уламжлалт эрэгтэйлэг байдлыг нэмэгдүүлж байна ($\beta = 0.3420$, $p < .001$)
- Улмаар уламжлалт эрэгтэйлэг байдал нь бие махбодийн түрэмгийллийг нэмэгдүүлж байсан ($\beta = 0.2118$, $p < .001$)
- Харин үүний эсрэгээр жендэрийн үүргийн зөрчил бага байснаар нь уламжлалт эмэгтэйлэг байдлыг нэмэгдүүлдэг ($\beta = -0.3535$, $p < .001$).
- Үүний үр дүнд, эмэгтэйлэг байдал нэмэгдэх тусам бие махбодийн түрэмгийлэл үйлдэх хандлагыг бууруулж байсан ($\beta = 0.0381$, $p = 0.459$).

Эдгээр үр дүнгээс дүгнэхэд, жендэрийн үүргийн зөрчил нь өөрөө шууд бие махбодийн түрэмгийлэлд хүчтэй нөлөөлөхгүй ч, дам замаар буюу эрэгтэйлэг шинжийг нэмэгдүүлж, эмэгтэйлэг шинжийг бууруулах замаар хүч хэрэглэсэн авирт нөлөөлж байгаа нь тогтоогдож байна. Уламжлалт жендэрийн хүлээлттэй зөрчилдөж буй өсвөр насны хүүхдүүд илүү хүчирхийлэл үйлдэх магадлалтай бөгөөд энэ нь тэдний жендэрийн баримжааны өөрчлөлт, дотоод үл нийцэлтэй нягт холбоотой байж болзошгүй юм.

Дүгнэлт

Судалгаанд оролцогчдын жендэрийн өөрийн

үнэлгээний үзүүлэлтээс харахад, эрэгтэй сурагчдын хувьд уламжлалт эрэгтэйлэг шинжүүд илүү давамгайл, эмэгтэй сурагчид эмэгтэйлэг чанарыг илүү үнэлсэн нь жендэрийн хэвшмэл ойлголт боловсролын насанд хүрэхээс өмнөх үеэс эхлэн хүчтэй сууж эхэлдэг болохыг харуулж байна. Энэ хэвшмэл байдал нь хүүхдийн өөрийн зан үйлийг зохицуулах, илэрхийлэх хэлбэрт шууд болон шууд бус замаар нөлөөлж байгаа нь судалгааны үр дүнгээр батлагдлаа. Хүйсийн ялгаа нь зөвхөн эрэгтэйлэг болон эмэгтэйлэг шинжүүдийн түвшинд бус, бие махбодийн түрэмгий авирын илрэлд мөн илэрч байсан. Эрэгтэй хүүхдүүд бие махбодийн түрэмгийлэл илүү өндөр үзүүлэлттэй байсан бол эмэгтэй хүүхдүүд энэ тал дээр харьцангуй бага байсан нь уламжлалт жендэрийн хүлээлттэй нийцэж байв. Гэвч зан үйлийн бусад төрлүүд (жишээлбэл, үгэн түрэмгийлэл, уур хилэн, дайсагнал гэх мэт) дээр хүйсийн ялгаа ажиглагдаагүй нь түрэмгий зан үйл нь зөвхөн хүйсийн ялгаанд бус харин дотоод сэтгэлзүйн зөрчил, нийгмийн хүлээлттэй зөрчилдөөнөөс шалтгаалж байж болохыг илтгэнэ. Жендэрийн үүргийн зөрчил нь шууд бие махбодийн түрэмгийлэлд нөлөө үзүүлээгүй ч зуучлагч хувьсагч болох эрэгтэйлэг байдлаар дамжин дам нөлөө үзүүлж байв. Энэ нь жендэрийн үүргийн зөрчил нь шууд илэрхийлэх түрэмгий зан авирын хэлбэрээс илүү дотоод зан үйлийн механизм, тухайлбал нийгмийн хүлээлтэд нийцэх гэж хичээх явцад бий болдог зан үйлийн өөрчлөлтөөр дамжин илэрдэг болохыг харуулж байна. Насны хувьд эрэгтэйлэг байдалд тодорхой ялгаа ажиглагдсан бөгөөд ахлах ангийн сурагчдын хувьд энэхүү шинж чанар илүү өндөр илэрч байсан. Энэ нь нас нэмэгдэхийн хэрээр хүүхдүүд уламжлалт эрэгтэйлэг хэв маягийг илүү дагаж, тэр хэрээр сэтгэл хөдлөлөө илэрхийлэх бус харин хүч хэрэглэсэн зан үйлээр дамжуулан хариу үйлдэл үзүүлэх магадлал өндөр болж байгааг илтгэж байна. Харин жендэрийн үүргийн зөрчил, түрэмгий зан авирт нас, эцэг эхтэй амьдарч буй эсэхээс шалтгаалж ялгаа илрээгүй нь нь гэр бүлийн бүтэц бус, сэтгэлзүйн хүлээлт ба нийгмийн орчин илүү нөлөөтэй болохыг харуулж байна.

Conflict of Interest Statement

Зохиогчид задруулах ашиг сонирхлын зөрчил байхгүй гэж мэдэгдэж байна.

Ethics

Судалгааны аргачлал, таниулсан зөвшөөрлийн тухай МУИС-ийн Сэтгэл судлалын тэнхимийн хурлаар хэлэлцэж зөвшөөрөл олгосон магистрийн судалгааны ажил болно.

References

- Addis, M. E., & Mahalik, J. R. (2003). Men, masculinity, and the contexts of help seeking. *American Psychologist*, 58(1), 5–14. <https://doi.org/10.1037/0003-066X.58.1.5>
- Archer, J. (2004). Sex differences in aggression in real-world settings: A meta-analytic review. *Review of General Psychology*, 8(4), 291–322. <https://doi.org/10.1037/1089-2680.8.4.291>
- Bem, S. L. (1981). Gender schema theory: A cognitive account of sex typing. *Psychological Review*, 88(4), 354–364. <https://doi.org/10.1037/0033-295X.88.4.354>
- Brown, M. J., & Gladstone, N. (2012). Development of a short version of the gender role beliefs scale. *International Journal of Psychology and Behavioral Sciences*, 2(5), 154–158.
- Eagly, A. H. (1987). *Sex differences in social behavior: A social-role interpretation*. Erlbaum.
- Eagly, A. H., & Wood, W. (2012). Social role theory. In P. A. M. V. Lange, A. W. Kruglanski, & E. T. Higgins (Eds.), *Handbook of theories of social psychology* (Vol. 2, pp. 458–476). Sage.
- Fidazzo, A., Barron, M., & Steeves, T. (2022). Feminine ideology, body appreciation, and indirect aggression in girls. *Frontiers in Education*, 7, 896247. <https://doi.org/10.3389/feduc.2022.896247>
- Good, G. E., & Mintz, L. B. (1990). Gender role conflict and depression in men: Evidence for compounded risk. *Journal of Counseling & Development*, 69(1), 17–21. <https://doi.org/10.1002/j.1556-6676.1990.tb01454.x>
- Grimmell, C. L., & Stern, B. A. (1998). Effects of gender-role self-discrepancy on depressed mood. *Sex Roles*, 39(3-4), 203–214. <https://doi.org/10.1023/A:1018898320768>
- Hyde, J. S. (1984). How large are cognitive gender differences? A meta-analysis using ω^2 . *American Psychologist*, 39(8), 999–1015. <https://doi.org/10.1037/0003-066X.39.8.999>
- Kachel, S., Steffens, M. C., & Niedlich, C. (2016). Traditional masculinity and femininity: Validation of a new scale assessing gender roles. *Frontiers in Psychology*, 7, 956. <https://doi.org/10.3389/fpsyg.2016.00956>
- Mahalik, J. R., Locke, B. D., Ludlow, L. H., Diemer, M. A., Scott, R. P. J., Gottfried, M., & Freitas, G. (2003). Development of the Conformity to Masculine Norms Inventory. *Psychology of Men & Masculinity*, 4(1), 3–25. <https://doi.org/10.1037/1524-9220.4.1.3>
- Malonda-Vidal, E., Meléndez, J. C., & Satorres, E. (2021). Traditional masculinity and aggression in adolescence: Its relationship with emotional processes. *International Journal of Environmental Research and Public Health*, 18(18), 9802. <https://doi.org/10.3390/ijerph18189802>
- Merino, E., Díaz-Aguado, M. J., Falcón, L., & Martínez-Arias, R. (2021). Masculine gender role stress as a mediator of the relationship between justification of dominance and aggression and male adolescent dating violence against women. *Psicothema*, 33(2), 206–213. <https://doi.org/10.7334/psicothema2020.275>
- O’Neil, J. M. (1981). Patterns of gender role conflict and strain. *The Counseling Psychologist*, 9(2), 61–80. <https://doi.org/10.1177/001100008100900213>
- O’Neil, J. M. (2008). Summarizing 25 years of research on men’s gender role conflict using the Gender Role Conflict Scale. *The Counseling Psychologist*, 36(3), 358–445. <https://doi.org/10.1177/0011000008317057>
- Williams, J. E., & Best, D. L. (1980). *Measuring sex stereotypes: A multination study*. Sage.
- Zillmann, D. (1978). Attribution and misattribution of excitatory reactions. In J. H. Harvey, W. Ickes, & R. F. Kidd (Eds.), *New directions in attribution research* (Vol. 2, pp. 335–368). Erlbaum.